



САНХҮҮГИЙН Т АЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Баян-Адарга сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХЭА-2026/003/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Чингис хот
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ж.Ганбаатар
Утас: 70562112

Аудитын менежер: Д.Оюунтуяа
Утас: 99775390

Ахлах аудитор: Г.Энх-Амгалан
Утас: 91119424

Цахим хаяг: www.audit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗАР**

АЗДТГ-ын 3 дугаар давхарт, Сариг баг, Хэрлэн сум,
Хэнтий аймаг, 23119, Утас/Факс: (976) 70562112,
Цахим шуудан: khentii@audit.gov.mn

2026.03.25 № 534

танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хэнтий аймгийн Баян-Адарга сумын Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн нэгтгэсэн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давж дангаараа буюу нийт дүнгээрээ материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

Засаг даргын тамгын газар

Төсвийн хөрөнгөөр 1 ширхэг DJI air mavic 3 pro drone, DJI микрофоныг зах зээлийн үнээс өндөр үнээр худалдан авсан, Олон нийтийн цагдаагийн ажилтны урамшууллыг үндсэн үйл ажиллагааны зардлаас олгосон, өмнөх оны авлагыг барагдуулах талаар арга хэмжээ аваагүй, тооцоо нийлж баталгаажуулаагүй, Онцгой байдлын албаны аврах, эрэн хайх албаны ажилтны усны хувцас хэрэгслийг тендер зарлалгүй шууд худалдан авалт хийсэн.

Иргэдийн төлөөлөгчдийн хурал

Сумын ИТХ-ын төлөөлөгч нарт албан томилолтыг үндсэн үйл ажиллагааны зардлаас олгосон.

Эдгээр зөрчил нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.2 “төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “Үнэн зөв байх”, 18 дугаар зүйлийн 18.1 “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.4 “нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах”, 20.2.5 “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах, 20.2.6-эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.5. “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулсан хөрөнгийг дараах чиглэлээр зарцуулна”, 46.5.8-д “Олон нийтийн цагдаагийн урамшуулал, эрүүл мэндийн даатгалын зардлыг санхүүжүүлэх”, гэснийг зөрчсөн нь санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, толилуулга, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг тус тус хангахгүй байна

Асуудлыг онцолсон хэсэг

Баян-Адарга сум 2025 онд 532,944.0 мянган төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 578,210.9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 45,266.9 мянган төгрөгөөр буюу 108.5 хувиар биелүүлж, аймгийн төсвөөс 1,281,689.7 мянган төгрөгийн дэмжлэг авсан байна. Татварын орлогыг нэр төрлөөр авч үзвэл үл хөдлөх хөрөнгийн албан татвар тасарсан байна.

Аудитын гол асуудал

Баян-Адарга сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар 5,006,784.5 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 4,982,639.8 мянган төгрөгийн 2 алдааг залруулж, 23,035.6 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 1,109.1 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж хүргүүлэв.

Бусад асуудлын хэсэг

Сумын Иргэдийн төлөөлөгчдийн 2025 оны 12 дугаар сарын 13-ны хуралдааны 2 дугаар тогтоолоор сумын Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг 91.4 хувь, "Хангалттай" гэж дүгнэсэн байна.

Цаашид төсвийн төсвийн орлого, зарлагыг үндэслэлтэй төлөвлөж, орлогыг нэр төрлөөр нь биелүүлэх, батлагдсан төсөл, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах шаардлагатай байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж. ГАНБААТАР

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

(Мянган төгрөгөөр)

№	Дансны нэр, төрөл	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1. ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		1,558,595.21	1,370,358.42
2	1.1.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	668,936.70	737,232.85
3	1.1.3 АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	216,805.51	109,819.59
4	1.1.4 УРЬДЧИЛГАА	7а, 7б	223,590.09	9,722.67
5	1.1.5 БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	449,262.91	513,583.31
6	1.2 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		5,003,407.85	7,355,043.36
7	1.2.2 ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	5,003,407.85	7,355,043.36
8	1.2.2.02 Биет хөрөнгө		4,823,929.10	7,175,658.36
9	1.2.2.03 Биет бус хөрөнгө	13	179,478.75	179,385
10	1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2		6,562,003.06	8,725,401.78
11	2.1 НИЙТ ӨР ТӨЛБӨР		9,355.79	48,754.93
12	2.1.1 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		9,355.79	48,754.93
13	2.1.1.03 Өглөг		9,355.79	48,754.93
14	2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		6,552,647.27	8,676,646.85
15	2.2.1 Засгийн газрын хувь оролцоо		6,552,647.27	8,676,646.85
16	2.2.1.01 Засгийн газрын оруулсан капитал		1,105,851.44	1,105,851.44
17	2.2.1.02 Өмч /төрийн/ /ТӨҮГ/		745,529.7	765,547.97
18	2.2.1.08 Хуримтлагдсан үр дүн		4,635,671.51	6,738,439.82
19	2.2.1.09 Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		65,594.62	66,807.62
20	2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5		6,562,003.06	8,725,401.78

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

(Мянган төгрөгөөр)

№	Дансны нэр, төрөл	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН		2,483,996.44	4,574,832.02
2	1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО		609,270.73	554,459.57
3	1.1.1.03.1 Орлогын албан татвар		404,730.46	401,828.73
4	1.1.1.03.1.01 Хувь хүний орлогын албан татвар		404,730.46	401,828.73
5	1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар		84,139.49	77,013.51
6	1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж		120,400.78	75,617.33
7	1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	326,392.61	4,020,372.45
8	1.1.1.04.3 Тусламжийн орлого		0.0	1,335,197.78
9	1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО		1,548,333.1	0.0
10	1.1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	1,794,679.36	2,213,779.51
11	1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ		1,794,679.36	2,202,361.7
12	1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,774,677.25	2,200,714.99
13	1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		657,930.97	845,311.35
14	1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		78,094.95	103,894.45
15	1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		499,310.92	548,056.34
16	1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал		97,046.03	60,809.23
17	1.1.2.01.1.05 Нормативт зардал		7,081.5	2,868.46
18	1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал		19,772.98	51,616.9
19	1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал		19,114	28,890
20	1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		193,781.55	225,721.39
21	1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал		202,544.36	333,546.87
22	1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		20,002.11	1,646.71
23	1.1.2.02 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		0.0	11,417.81
24	1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		689,317.08	2,361,052.52
25	1.2.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		750	0.0
26	1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)		-750	0.0
27	1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)		688,567.08	2,361,052.52

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (Мянган төгрөгөөр)

№	Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө /өмч
1	1.1.1.1.1.1 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,856,238.56		5,856,238.56
2	1.1.1.1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	2,625		2,625
3	1.1.1.1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,858,863.56		5,858,863.56
4	1.1.1.1.5 Өмчид гарсан өөрчлөлт	5,216.63		5,216.63
5	1.1.1.1.7 Тайлант үеийн үр дүн	688,567.08		688,567.08
6	1.1.1.1 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,552,647.27		6,552,647.27
7	1.1.1 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	6,552,647.27		6,552,647.27
8	1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-258,284.21		-258,284.21
9	1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,294,363.06		6,294,363.06
10	1.2 Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	1,213		1,213
11	1.5 Өмчид гарсан өөрчлөлт	20,018.27		20,018.27
12	1.7 Тайлант үеийн үр дүн	2,361,052.52		2,361,052.52
13	1 2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	8,676,646.85		8,676,646.85

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

(Мянган төгрөгөөр)

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1.1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	2,319,046.73	2,396,353.18
2	1.1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО	609,270.73	554,459.57
3	1.1.1.1.03.1 Орлогын албан татвар	404,730.46	401,828.73
4	1.1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар	84,139.49	77,013.51
5	1.1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж	120,400.78	75,617.33
6	1.1.1.1.03.8.01 Бусад нийтлэг төлбөр, хураамж	27,684.17	22,193.69
7	1.1.1.1.03.8.02 Газрын төлбөр	8,340.14	8,803.67
8	1.1.1.1.03.8.03 Байгалийн нөөц ашигласны төлбөр	84,376.47	44,619.96
9	1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	160,842.91	1,841,893.61
10	1.1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого	160,842.91	256,803.83
11	1.1.1.1.04.3 Тусламжийн орлого	0.0	1,335,197.78
12	1.1.1.1.04.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.0	249,892
13	1.1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,548,933.1	0.0
14	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,645,653.72	1,931,175.81
15	1.1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	1,645,653.72	1,931,175.81
16	1.1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,618,698.85	1,912,081.73
17	1.1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	708,908.18	912,291.33
18	1.1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	89,832.04	101,509.08
19	1.1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	499,310.92	541,885.44
20	1.1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	63,878.12	87,894.49
21	1.1.1.2.01.1.05 Нормативт зардал	1,807.1	1,178
22	1.1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	37,142.68	81,704.7
23	1.1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал	19,114	28,890
24	1.1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	114,246.76	82,133.72
25	1.1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	84,459.05	74,594.97
26	1.1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	26,954.87	19,094.08
27	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	673,393.01	465,177.37
28	1.1.2.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	225,040.99	396,881.22
29	1.1.2.2.01 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	225,040.99	396,881.22
30	1.1.2.2.01.1 Дотоод эх үүсвэрээр	225,040.99	396,881.22
31	1.1.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-225,040.99	-396,881.22
32	1.1.3.2 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	750	0.0
33	1.1.3 САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-750	0.0
34	1.1 НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	447,602.02	68,296.15
35	1.2 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	221,334.68	668,936.7
36	1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	668,936.7	737,232.85

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(Мянган төгрөгөөр)

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	3.1.01.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	3,900,859.4	3,792,016.9	108,842.5
11	3.1.01.1.1 Татварын орлого	514,140.0	554,459.6	(40,319.6)
110	3.1.01.1.1.1 Орлогын албан татвар	382,500.0	401,828.7	(19,328.7)
1100	3.1.01.1.1.1.1 Хувь хүний орлогын албан татвар	382,500.0	401,828.7	(19,328.7)
110001	3.1.01.1.1.1.1.01 Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	308,000.0	309,966.5	(1,966.5)
110002	3.1.01.1.1.1.1.02 Үйл ажиллагааны орлого	45,500.0	49,851.0	(4,351.0)
110003	3.1.01.1.1.1.1.03 Хөрөнгийн орлого	28,000.0	39,461.8	(11,461.8)
110004	3.1.01.1.1.1.1.04 Хөрөнгө борлуулсны орлого	1,000.0	2,549.4	(1,549.4)
113	3.1.01.1.1.3 Хөрөнгийн албан татвар	65,800.0	77,013.5	(11,213.5)
113001	3.1.01.1.1.3.1 Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	4,000.0	2,890.9	1,109.1
113002	3.1.01.1.1.3.2 Бууны албан татвар	1,800.0	2,220.0	(420.0)
113004	3.1.01.1.1.3.4 Малд ногдуулах албан татвар	60,000.0	71,902.6	(11,902.6)
118	3.1.01.1.1.8 Бусад татвар, төлбөр, хураамж	65,840.0	75,617.3	(9,777.3)
1180	3.1.01.1.1.8.1 Бусад нийтлэг төлбөр, хураамж	17,400.0	22,193.7	(4,793.7)
118001	3.1.01.1.1.8.1.01 Улсын тэмдэгтийн хураамж	2,400.0	3,432.0	(1,032.0)
118006	3.1.01.1.1.8.1.06 Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	-	864.1	(864.1)
118009	3.1.01.1.1.8.1.08 Хог хаягдлын үйлчилгээний хураамж	15,000.0	17,897.5	(2,897.5)
1181	3.1.01.1.1.8.2 Газрын төлбөр	6,500.0	8,803.7	(2,303.7)
118101	3.1.01.1.1.8.2.01 Газрын төлбөр	6,500.0	8,803.7	(2,303.7)
1182	3.1.01.1.1.8.3 Байгалийн нөөц ашигласны төлбөр	41,940.0	44,620.0	(2,680.0)
118201	3.1.01.1.1.8.3.01 Ойн нөөц ашигласны төлбөр	17,690.0	18,186.7	(496.7)
118202	3.1.01.1.1.8.3.02 Ан амьтны нөөц ашигласны төлбөр	24,250.0	26,433.2	(2,183.2)
12	3.1.01.1.2 Татварын бус орлого	3,386,719.4	3,237,557.4	149,162.0
120	3.1.01.1.2.1 Нийтлэг татварын бус орлого	48,804.0	175,217.2	(126,413.2)
120003	3.1.01.1.2.1.3 Торгуулийн орлого	9,504.0	15,714.3	(6,210.3)
120004	3.1.01.1.2.1.4 Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	30,000.0	125,229.3	(95,229.3)
120010	3.1.01.1.2.1.5 Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	8,300.0	34,255.1	(25,955.1)
120009	3.1.01.1.2.1.9 Бусад орлого	1,000.0	18.5	981.5
122	3.1.01.1.2.3 Тусламжийн орлого	3,088,023.4	2,812,448.1	275,575.3
122003	3.1.01.1.2.3.3 Аймаг нийслэлээс авсан татаас	1,281,689.7	1,281,689.7	-
122005	3.1.01.1.2.3.5 Төсвөөс санхүүжих	1,806,333.7	1,530,758.4	275,575.3

123	3.1.01.1.2.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	249,892.0	249,892.0	-
123002	3.1.01.1.2.4.2 Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	249,892.0	249,892.0	-
II	3.1.01.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,734,751.6	4,104,757.6	(1,370,006.0)
21	3.1.01.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ	2,146,064.6	3,761,604.0	(1,615,539.4)
210	3.1.01.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,137,901.7	1,848,657.6	289,244.1
2101	3.1.01.2.1.1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	963,906.1	843,809.5	120,096.6
210101	3.1.01.2.1.1.1.01 Үндсэн цалин	435,882.3	418,588.3	17,294.0
210102	3.1.01.2.1.1.1.02 Нэмэгдэл	296,212.9	265,736.4	30,476.5
210103	3.1.01.2.1.1.1.03 Унаа хоолны хөнгөлөлт	47,430.0	40,506.8	6,923.2
210104	3.1.01.2.1.1.1.04 Урамшуулал	85,306.1	38,663.8	46,642.4
210105	3.1.01.2.1.1.1.05 Гэрээт ажлын хөлс	99,074.8	80,314.3	18,760.5
2102	3.1.01.2.1.1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	120,488.6	101,509.1	18,979.5
210201	3.1.01.2.1.1.2.01 Тэтгэврийн даатгал	81,932.2	70,429.9	11,502.3
210202	3.1.01.2.1.1.2.02 Тэтгэмжийн даатгал	9,639.1	8,431.8	1,207.3
210203	3.1.01.2.1.1.2.03 ҮОМШӨ-ний даатгал	4,819.6	4,256.5	563.1
210204	3.1.01.2.1.1.2.04 Ажилгүйдлийн даатгал	4,819.6	3,647.1	1,172.5
210205	3.1.01.2.1.1.2.05 Эрүүл мэндийн даатгал	19,278.1	14,743.8	4,534.3
2103	3.1.01.2.1.1.3 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	565,426.4	541,885.4	23,541.0
210301	3.1.01.2.1.1.3.01 Гэрэл, цахилгаан	97,349.4	73,323.6	24,025.8
210302	3.1.01.2.1.1.3.02 Түлш, халаалт	444,915.0	443,414.8	1,500.2
210303	3.1.01.2.1.1.3.03 Цэвэр, бохир ус	23,162.0	25,147.0	(1,985.0)
2104	3.1.01.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал	52,462.5	38,864.6	13,597.9
210401	3.1.01.2.1.1.4.01 Бичиг хэрэг	8,910.7	4,272.5	4,638.2
210402	3.1.01.2.1.1.4.02 Тээвэр, шатахуун	34,494.4	30,107.1	4,387.3
210403	3.1.01.2.1.1.4.03 Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,357.5	2,615.8	2,741.7
210405	3.1.01.2.1.1.4.05 Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,145.0	548.8	596.2
210406	3.1.01.2.1.1.4.06 Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,554.9	1,320.4	1,234.5
2105	3.1.01.2.1.1.5 Нормативт зардал	4,807.1	1,178.0	3,629.1
210503	3.1.01.2.1.1.5.03 Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,807.1	1,178.0	3,629.1
2106	3.1.01.2.1.1.6 Эд хогшил, урсгал засварын зардал	132,080.9	120,435.0	11,645.9
210601	3.1.01.2.1.1.6.01 Багаж, техник, хэрэгсэл	61,693.9	57,175.1	4,518.8
210602	3.1.01.2.1.1.6.02 Тавилга	10,000.0	10,000.0	-
210603	3.1.01.2.1.1.6.03 Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	943.1	-	943.1
210604	3.1.01.2.1.1.6.04 Урсгал засвар	59,443.9	53,259.9	6,184.0

Хэнтий аймгийн Баян-Адарга сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2107	3.1.01.2.1.1.7 Томилолт, зочны зардал	31,489.0	28,890.0	2,599.0
210702	3.1.01.2.1.1.7.02 Дотоод албан томилолт	31,489.0	28,890.0	2,599.0
2108	3.1.01.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	178,025.8	126,378.7	51,647.1
210801	3.1.01.2.1.1.8.01 Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	172,681.9	123,624.2	49,057.7
210802	3.1.01.2.1.1.8.02 Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	338.9	-	338.9
210803	3.1.01.2.1.1.8.03 Даатгалын үйлчилгээ	1,014.3	363.5	650.9
210804	3.1.01.2.1.1.8.04 Тээврийн хэрэгслийн татвар	536.4	341.8	194.6
210805	3.1.01.2.1.1.8.05 Тээврийн хэрэгслийн оношлогоо	245.6	121.0	124.6
210806	3.1.01.2.1.1.8.06 Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,245.2	1,504.0	741.2
210807	3.1.01.2.1.1.8.07 Газрын төлбөр	963.5	424.3	539.2
2109	3.1.01.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал	89,215.3	45,707.3	43,508.0
210901	3.1.01.2.1.1.9.01 Бараа үйлчилгээний бусад зардал	74,538.9	38,917.5	35,621.4
210902	3.1.01.2.1.1.9.02 Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	14,676.4	6,789.8	7,886.6
213	3.1.01.2.1.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,162.9	1,912,946.3	(1,904,783.4)
2131	3.1.01.2.1.4.1 Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	1,911,746.3	(1,911,746.3)
213103	3.1.01.2.1.4.1.03 Төсвийн санхүүжилт	-	1,911,746.3	(1,911,746.3)
2132	3.1.01.2.1.4.2 Бусад урсгал шилжүүлэг	8,162.9	1,200.0	6,962.9
213209	3.1.01.2.1.4.2.08 Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,162.9	1,200.0	6,962.9
22	3.1.01.2.2 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	475,167.7	343,153.6	132,014.1
223001	3.1.01.2.2.4 Бусад хөрөнгө	475,167.7	343,153.6	132,014.1
23	3.1.01.2.3 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	113,519.3	-	113,519.3
230001	3.1.01.2.3.1 Эргэж төлөгдөх зээл	113,519.3	-	113,519.3
8	3.1.01 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	1,166,107.8	(312,740.6)	1,478,848.4
9	3.1 АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	(1,166,107.8)	312,740.6	(1,478,848.4)
7	3 Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	(1,166,107.8)	312,740.6	(1,478,848.4)
4	4 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	661,480.5	(661,480.5)
5	5 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	729,727.8	(729,727.8)

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

(Мянган төгрөгөөр)

Дансны код	Дансны нэр, төрөл	Тайлант он
1	1.1.1.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	53,508.1
12	1.1.1.1.1 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	53,508.1
122	1.1.1.1.1.1 Тусламжийн орлого	53,508.1
1221	1.1.1.1.1.1.1 Хандив тусламж /дотоод/	53,508.1
12213	1.1.1.1.1.1.1.1 Нэмэлт санхүүжилтийн орлого	53,508.1
350014	1.1.1.1.1.1.1.4 Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	37,585.6
350015	1.1.1.1.1.1.1.5 Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	15,922.5
II	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	35,614.0
21	1.1.1.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ	35,614.0
210	1.1.1.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	35,614.0
2104	1.1.1.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал	350.0
210401	1.1.1.2.1.1.4.1 Бичиг хэрэг	350.0
2108	1.1.1.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,241.3
210801	1.1.1.2.1.1.8.1 Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,241.3
2109	1.1.1.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал	27,022.7
210901	1.1.1.2.1.1.9.1 Бараа үйлчилгээний бусад зардал	27,022.7
4	1.1.1 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	17,894.1
5	1.1 АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	(17,894.1)
6	1 Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	(17,894.1)

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Баян-Адарга сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд сумын орон нутгийн төсвийн 2 байгууллага, 2 ОНӨААТҮГ, 1 төрийн сан, 2 тусгай сан, улсын төсвийн 4 байгууллагын тогтмол зардал нийт 11 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 5 байгууллагад санал дүгнэлт гаргаж 6 байгууллагын санхүүгийн тайланд аудитын үе шатны ажлыг хэсэгчлэн гүйцэтгэлээ.

Аудитад хамрагдсан Засаг даргын тамгын газарт аймаг дахь Төрийн аудитын газар аудит хийж “Хязгаарлалттай”, Хүүхдийн цэцэрлэг, Ерөнхий боловсролын сургуульд “Ари файнэнс аудит” ХХК аудитыг хийж “Өөрчлөлтгүй”, Эрүүл мэндийн төвд “Платиниум прогресс аудит” ХХК аудит хийж “Өөрчлөлтгүй” санал дүгнэлт гаргасан байна. Баян-Адарга сумын ИТХ, Соёлын төв, Хоршоог хөгжүүлэх сан, ОНХС-нд санхүүгийн тайлангийн үе шатны ажлыг хэсэгчлэн гүйцэтгэсэн байна.

5.1 Тус сумын харьяа орон нутгийн болон улсын төсвийн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийн талаар

Орон нутгийн төсвийн байгууллагуудад илэрсэн алдаа, зөрчил

Орон нутгийн төсвийн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 144,375.1 мянган төгрөгийн 12 алдаа, зөрчил илэрснээс 71,291.7 мянган төгрөгийн 4 алдааг аудитын явцад залруулж, 73,083.4 мянган төгрөгийн зөрчлийг таслан зогсоох 7 албан шаардлага хүргүүлж, байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг сайжруулах 1 зөвлөмж өгсөн байна.

Аудитын илрүүлэлт:

Орон нутгийн төсвийн байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

Засаг даргын тамгын газар:

- ✓ Төсвийн хөрөнгөөр 1 ширхэг DJI air mavic 3 pro drone, DJI микрофоныг 14.5 сая төгрөгөөр буюу зах зээлийн үнээс 7,600.0 мянган төгрөгөөр өндөр үнээр худалдан авсан зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.
- ✓ Олон нийтийн цагдаагийн ажилтны урамшуулалд 8,500.0 мянган төгрөг, ажил олгогчоос төлөх НДШ-д 1,092.4 мянган төгрөг нийт 9,592.4 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны зардлаас олгосон зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.
- ✓ Өмнөх онд 12,242.0 мянган төгрөгийн өвсийг зарж борлуулж авлага үүсгэж санхүүгийн тайланд тусгасан боловч авлагыг барагдуулах талаар арга хэмжээ аваагүй, тооцоо нийлж баталгаажуулаагүй зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.
- ✓ Онцгой байдлын албаны аврах, эрэн хайх албаны ажилтны усны хувцас хэрэгслийг 24,500.0 мянган төгрөгөөр тендер зарлалгүй шууд худалдан авалт хийсэн зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.
- ✓ Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үлдэх өртөггүй 56 нэр төрлийн 138 ширхэг хөрөнгийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу шийдвэрлээгүй зөрчилд зөвлөмж хүргүүлсэн.
- ✓ Санхүүгийн тайлангаарх үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал нь үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлээс 54,521.1 мянган төгрөгөөр зөрүүтэй байсныг санхүүгийн тайланд залруулсан.
- ✓ ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн Гэрэлтүүлэг төсөл, арга хэмжээний үндсэн хөрөнгийг данс бүртгэлд 4,531.7 мянган төгрөгөөр дутуу тусгасныг санхүүгийн тайланд залруулсан.

Иргэдийн төлөөлөгчдийн хурал:

- ✓ Сумын ИТХ-ын төлөөлөгч нарт 7,230.0 мянган төгрөгийн албан томилолтыг үндсэн үйл ажиллагааны зардлаас олгосон зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.
- ✓ Тэмцээн уралдаан зохион байгуулах, оролцоход 419.0 мянган төгрөгийн зарцуулсан зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

Хоршоо хөгжүүлэх сан:

- ✓ Сангийн зээлийн хүүгийн авлага 7,707.1 мянган төгрөгийг зээлийг авлагаас салгаж бүртгээгүй алдааг санхүүгийн тайланд залруулсан.

Орон нутгийн хөгжлийн сан:

- ✓ Шилэн дансны цахим системд 2 төсөл арга хэмжээний 11,500.0 мянган төгрөгийн мэдээллийг байршуулаагүй зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.
- ✓ Гэрэлтүүлэг шинээр нэмэх ажлыг бүртгэхдээ гэрээний дүнгээс 4,531.8 мянган төгрөгөөр дутуу бүртгэсэн алдааг санхүүгийн тайланд залруулсан.

Улсын төсвийн байгууллагуудад гарсан алдаа зөрчил.

Улсын төсвийн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 127,290.7 мянган төгрөгийн 14 алдаа, зөрчил илэрснээс 116,497.4 мянган төгрөгийн 6 алдааг аудитын явцад залруулж, 983.9 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 6,287.3 мянган төгрөгийн зөрчлийг таслан зогсоох 5 албан шаардлага хүргүүлж, 3,522.1 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгсөн байна.

Аудитын илрүүлэлт:

Улсын төсвийн байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

Ерөнхий боловсролын сургууль:

- ✓ Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээ дээрх Засгийн газрын өмчийн дүн санхүүгийн тайлан дахь өмчийн дүн зөрүүтэй зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.
- ✓ Байгууллагын даргын тушаалаар жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого зохион байгуулах комиссыг томилж хөрөнгийн тооллогыг гүйцэтгүүлсэн боловч тооцоо бодсон акт үйлдэж, үлдэгдлийг баталгаажуулаагүй малын тооллого хийгээгүй зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.
- ✓ Бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлэх зэргээр бичгийн цаас, хувилагч, хэвлэгчийн хорны зардлыг хэмнэж ажиллаагүй батлагдсан төсвийг 3,522.1 мянган төгрөгийг хэтрүүлсэн зөрчилд зөвлөмж хүргүүлсэн.
- ✓ Тайлант онд худалдаж авсан 17,029.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг мөнгөн гүйлгээний тайланд бараа үйлчилгээний зардлаар бүртгэснийг санхүүгийн тайланд залруулсан.

Соёлын төв:

- ✓ Он дамжсан 2,302.2 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй зөрчилд зөвлөмж хүргүүлсэн.
- ✓ Төсвийн тохируулгын тайлан бэлтгээгүй, төсвийн гүйцэтгэлийн тайланг цэвэр дүнгээр гаргаагүй 36,447.2 мянган төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулсан.
- ✓ Орон нутгийн төсвийн санхүүжилт 6,000.0 мянган төгрөгийг улсын төсвийн санхүүжилтийн орлогоор бүртгэснийг санхүүгийн тайланд залруулсан.

Хүүхдийн цэцэрлэг:

- ✓ Ур чадварын нэмэгдлийг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлээгүй, аль түвшинд амжилт гаргасныг нотлох баримтгүйгээр 6 ажилтанд 10-25 хувиар, цэцэрлэгийн эрхлэгчид 15 хувиар тус тус тооцож 2,985.1 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл олгосон зөрчилд албан шаардлага хүргүүлсэн
- ✓ Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээ дээрх Засгийн газрын өмчийн дүн санхүүгийн тайлан дахь өмчийн дүн зөрүүтэй зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.
- ✓ Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 27 нэр төрлийн (анхны өртөг 24,589.0 мянган төгрөг) хөрөнгийг дахин үнэлж бүртгээгүй зөрчилд зөвлөмж өгсөн.
- ✓ Санхүүгийн байдлын тайлан тайлан дэлгэрэнгүй, хураангуй бүртгэлтэй тулган шалгахад 312.0 мянган төгрөгөөр зөрүүтэй бүртгэснийг санхүүгийн тайланд залруулсан.
- ✓ Ажилтнуудын цалингаас суутгасан хувь хүний орлогын албан татвар 23,368.0 мянган төгрөгийг өглөгийн дансанд бүртгэлгүй шилжүүлсэн алдааг залруулсан.
- ✓ Ажилтнуудын цалингаас суутгасан нийгмийн даатгалын шимтгэл 33,311.2 мянган төгрөгийг өглөгийн дансанд бүртгэлгүй шилжүүлсэн алдааг санхүүгийн тайланд залруулсан.

Эрүүл мэндийн төв:

- ✓ Тайлант онд нэг албан хаагчид илүү цагийн хөлсөнд 983.8 мянган төгрөгийг тушаал шийдвэргүй олгосон зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

Баян-Адарга сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар 5,006,784.5 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 4,982,639.8 мянган төгрөгийн 2 алдааг залруулж, 23,035.6 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 1,109.1 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж хүргүүлэв.

Залруулсан алдаа:

- ✓ Санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн өмнөх оны үйл ажиллагааны орлогын дүн 2,041,358.6 мянган төгрөг, тайланд оны дүн 2,937,065.4 мянган төгрөг, нийт 4,978,424.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлан ирүүлснийг санхүүгийн тайланд залруулсан.
- ✓ Татварын 4.215.8 мянган төгрөгийн замд яваа орлогыг нэгтгэсэн тайланд тусгаагүйг санхүүгийн тайланд залруулсан.

Зөрчил

Санхүүгийн тайлангийн аудитаар 24,144.7 мянган төгрөгийн зөрчил илэрч 23,035.6 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 1,109.1 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж хүргүүлээ.

5.1 Төлбөрийн акт

Байхгүй

5.2 АЛБАН ШААРДЛАГА

- ✓ Сумын ИТХ-ын тогтоолд Хоршоог хөгжүүлэх сангийн эхний үлдэгдлээс санхүүжих дүнг 599.9 мянган төгрөгөөр илүү, Орон нутгийн хөгжлийн сангийн эхний үлдэгдлээс санхүүжих эх үүсвэрийг 22,435.6 мянган төгрөг дутуу, нийт 23,035.5 мянган төгрөгийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг үндэслэлгүй төлөвлөж батлуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2-т "жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх", 57 дугаар зүйлийн 57.3-т "Орон нутгийн төсвийн

урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэх зарлагыг төсөвт тусган баталж хэрэгжүүлэх ба зарлага нь санхүүжүүлэх эх үүсвэрээсээ хэтрэхгүй байна" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн.

5.3 Зөвлөмж

Орлогын төлөвлөгөөний биелэлттэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

- ✓ Сумын ИТХ-аар баталсан үл хөдлөх хөрөнгийн албан татварын орлого 1,109.1 мянган төгрөгөөр орлогын төлөвлөгөөг биелээгүй байна.

Өгсөн зөвлөмж:

- ✓ Татварын орлогын төлөвлөгөөг нэр төрөл бүрээр биелүүлэх арга хэмжээ авч ажиллах.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт албан бичгээр тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгалгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруул аагүй	
							Тоо	Дүн	Тоо	Дүн
ЗДТГ	2	59,052.8	1	4,531.7	1	54,521.1	2	59,052.8		
ОНХС	1	4,521.8	1	4,531.8			1	4,521.8		
ХХС	1	7,707.1			1	7,707.1	1	7,707.1		
ОН-ын байгууллагын дүн	4	71,291.7	2	9,063.5	2	62,228.2	4	71,291.7		
<i>ЕБС</i>	1	17,029.0			1	17,029.0	1	17,029.0		
<i>Соёлын төв</i>	2	42,477.2			2	42,477.2	2	42,477.2		
<i>Цэцэрлэг</i>	3	56,991.2			3	56,991.2	3	56,991.2		
УТ-ын байгууллагын дүн	6	116,497.4			6	116,497.4	6	116,497.4		
ТТЗ	2	4,982,639.8	2	4,982,639.8			2	4,982,639.8		
ДҮН	12	5,170,428.9	4	4,991,703.3	8	178,725.6	12	5,170,428.9		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ЗДТГ	5	53,934.4	-	-	4	53,934.4	1	-
ИТХ	1	7,230.0	-	-	1	7,230.0		
			-	-				
ОН-ын байгууллагын дүн	6	61,164.4	-	-	5	61,164.4	1	-
<i>Эрүүл мэндийн төв</i>	1	983.9	1	983.9	-	-	-	-
<i>ЕБС</i>	3	3,522.1			2	-	1	3,522.1
<i>Соёлын төв</i>	1	3,302.2			1	3,302.2		
<i>Цэцэрлэг</i>	2	2,985.1			1	2,985.1	1	-
УТ-ын байгууллагын дүн	7	10,793.2	1	983.9	4	6,287.3	2	3,522.1
ТТЗ	2	24,144.7			1	23,035.6	1	1,109.1
Дүн	15	96,102.3	1	983.9	10	90,487.3	4	4,631.2

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
ОНХС	1	11,500.0			1	11,500.0		
ОН-ын байгууллагын дүн	1	11,500			1	11,500		
Шилэн дансны нийт дүн	1	11,500			1	11,500		
Бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
ИТХ	1	419.0			1	419.0		
ОН-ийн байгууллагын дүн	1	419.0			1	419.0		
Цэцэрлэг	1	-			1	-		
УТ-ийн байгууллагын дүн	1	-			1	-		
Нийт дүн	2	419.0			2	419.0		



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25

Дугаар 289-А/2360453
ХЭА-2026/003/НА-СТА-ТТЗ

Чингис хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймагын Баян-Адарга сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Сумын ИТХ-ын тогтоолд Хоршоог хөгжүүлэх сангийн эхний үлдэгдлээс санхүүжих дүнг 599,955.00 төгрөгөөр илүү, орон нутгийн хөгжлийн сангийн эхний үлдэгдлээс санхүүжих эх үүсвэрийг 22,435,638.00 төгрөгөөр дутуу, нийт 23,035,593.00 (хорин гурван сая гучин таван мянга таван зуун ерэн гурван) төгрөгийн эх үүсвэрийг үндэслэлгүй төлөвлөсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2-т "жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх", 57 дугаар зүйлийн 57.3-т "Орон нутгийн төсвийн урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэх зарлагыг төсөвт тусган баталж хэрэгжүүлэх ба зарлага нь санхүүжүүлэх эх үүсвэрээсээ хэтрэхгүй байна" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.5-д "төсвийн орлого, зарлагыг буруу тооцоолсон, төсөвт зардлыг хэтрүүлсэн" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийг санхүүжүүлэх эх үүсвэрт урьд оны үлдэгдлийг бүрэн төлөвлөдөггүй зөрчлийг арилган биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг сумын Засаг дарга О.Лхагвадорж-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

Ж.ГАНБААТАР

Г.ЭНХ-АМГАЛАН